“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын
захирлын 2025 оны 11 дугаар сарын 11-ны
өдрийн 0/99 дүгээр тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ ОНӨААТҮГ 7037793 СТА5713 9024060848

## АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | | |
|---|---|---|
| 1. Байгууллагын нэр: **“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ** | 2. Хэлтсийн нэр: **Санхүү, бүртгэлийн хэлтэс** | |
| 3. Ажлын байрны нэр: | 3.1 Албан тушаалтны ангилал: | 3.2. Албан тушаалтны зэрэглэл: |
| **Шатахуун түгээх станцын эрхлэгч** | - | - |
| 4. Шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр: | **Хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч** | |
| 5. Шууд харьяалагдан удирдах албан тушаалтан: | 5.1. Албан тушаалын нэр: Шатахуун түгээх станцын түгээгч нар | 5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо: |
| 6. Бусад харилцах субъект: | Тус байгууллагын бүх ажилтнууд | |
| Ажлын цаг: | 8 цаг | |
| Ажлын байрны албан ёсны байршил: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 10 дугаар хороо Морингийн даваа, оффиссын байр | |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Хэвийн | |
| Онцгой нөхцөл: | Хамаарахгүй | |

### II. АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**
Газрын тосны бүтээгдэхүүнийг батлагдсан технологийн зааврын дагуу хүлээн авах, хадгалах, түгээх ажил үйлчилгээг хууль, журмын дагуу зохион байгуулан гүйцэтгэхэд оршино.

**Албан тушаалын зорилт:**
1.Түлш захиалах, хүлээн авах, түгээх системд түлш оруулах, өдөр тутам болон сарын тооцоо гаргах, хэрэглээнд хяналт тавих, түлш хадгалах сав болон түгээгүүр, тоолуур, насос, шугам хоолой болон бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянах, мэдээлэх, засварлах ажлыг зохион байгуулах, хэмжих хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангах, хэмжих хэрэгслүүдийг зохих стандартын дагуу баталгаажилтад хамруулах, мэргэжлийн байгууллагуудын гаргасан заавар зөвлөмж, стандартуудыг дагаж мөрдөх;
2.ШТС-ын орлого, зарлагын тооцоо хийх, түлш хүлээн авах, хэвийн хорогдлын тооцоо хийх, анхан шатны бүртгэл маягтыг хөтлөх, түлш хадгалах сав, ШТС-ын галын аюулгүй байдлыг хангаж норм дүрэм стандартын хэрэгжилт, ШТС-ын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангуулах
3.Бусад

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэлбэр |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.1. ШТС-н тусгай зөвшөөрөл,түлш хадгалах сав, шатахуун түгээх станцын барилга байгууламжид техник, технологийн дүгнэлт шинээр болон шинэчлэн гаргахтай холбогдуулан үзлэг, шалгалт хийх; | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 1.2.Шатахууны чанар, стандартын байдалд хяналт тавих хүрээнд түүвэрлэн дээж авч, лабораториор шинжилгээ хийлгүүлэх, үр дүнг удирдлагад танилцуулах | Шатахуунашиглалт, хадгалалт хэвийн явагдсан байна. | Г |
| | 1.3.Түлшийг тээвэрлэх, хадгалах, чанарын шалгалт хийхэд ашиглах шахуурга, түгээгүүр, хэмжих, тохируулах, ачих, буулгах хэрэгсэл, хадгалах сав, дамжуулах хоолой, хаалт зэрэг механик болон автомат ажиллагаатай техник хэрэгслэл тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалтыг хариуцах; | Шатахуун зарцуулалтад хяналт хийгдсэн байна. | Г |
| | 1.4.Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, савлахад зориулсан байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, агуулахын барилга байгууламжийн ашиглалт, галын аюулгүй байдлыг хариуцах; | Шатахуун зарцуулалтын баримт үнэн көв, цаг хугацаандаа нэгтгэгдсэн байна. | Г |
| | 1.5.Газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг цэнэглэх, савласан бүтээгдэхүүний жижиглэнгээр олгоход зориулсан барилга, байгууламжийн цогцолбор ШТС-н өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх; | Шатахуун олголтод хяналт хийгдсэн байна. | Г |
| | 1.6.Гэрээт шатахуун тээвэрлэгч тээврийн хэрэгслийн зориулалтын зөвшөөрөгдсөн байр, зогсоол, талбайн ашиглалтыг хариуцах; | Шатахууны орлого, зарлагын баримт бүрдэж, данс бүртгэлд тусгагдсан байна. | Г |
| | 1.7.Тос, тосолгооны материал, тусгай шингэнийг зөвхөн зориулалтын саванд үйлдвэрийн аргаар технологийн дагуу савласан бүтээгдэхүүнийг олгох; | Аюулгүйн дүрмийг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 1.8.Түгээгч нарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдлын өдөр тутмын зааварчилгааг амаар болон бичгээр тогтмол өгч гарын үсэг зууруулж баталгаажуулна. | Ажилтнуудын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.1.Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийг цэвэрлэх, газрыг тэгшилж хөрсийг хэвийн байдалд оруулан ажилтны эрүүл мэнд, байгал орчинд хоргүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээж ургамалжуулах; Байгууламжийн аянга зайлуулагч, газардуулгын эсэргүүцлийг нь мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэх;<br>2.2.Холбогдох хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаар ариун цэвэр, эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах;хаб руу оруулах уу | Тушаалын хэрэгжилт бүрэн биелэгдэнэ.<br>ХХНЖ-ын дагуу баримтыг бүрэн хүлээлгэн өгсөн байдал<br>Үүрэг даалгаврын биелэлт, хувь | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.11.Ажил үүрэг гүйцэтгэж байхдаа олж мэдсэн төрийн болон албаны, хүний хувийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах.<br>3.12.Мэргэшил, ур чадвараа байнга дээшлүүлэх. | | |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| **Боловсрол** | Бакалавр болон түүнээс дээш |
| **Мэргэжил** | Эдийн засагч, Нягтлан бодогч |
| **Мэргэшил** | Газрын тосны чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно. |
| **Туршлага** | Шаардахгүй |
| **Ур чадвар** | Санал, санаачлага гаргах, салбар хүрээний болон хууль эрх зүйн мэдлэгтэй байх |
| | Багаар ажиллах чадвартай |
| | Асуудал шийдвэрлэх, тооцоолон бодох чадвартай |
| | Аливаа тооцоо, судалгаа хийх чадвартай байх. |

| IV. АЖИЛ, АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| Ажил, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Ажил, албан тушаалын тодорхойлолтыг хянасан: |
| Албан тушаал:Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга<br>.....................................Т.Алтангэрэл | Албан тушаал: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга<br>.....................................Н.Даариймаа |
| Ажил, албан тушаалын тодорхойлолтыг баталсан: | |
| Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ын захирал<br>.....................................Д.Жавхлан | |

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ ОНӨААТҮГ
7037793 СТА5713 9024060648